



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 1023

Улаанбаатар хот

“Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын
үед хадгаламж, зээлийн хоршоодод
авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 2.1.2, 2020 оны “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” 32 дугаар тогтоолын 2.5, Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 183 дугаар тогтоолын 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 145/124 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын зээлийн ангиллыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дор дурдсан байдлаар ангилж ажиллахыг хадгаламж, зээлийн хоршооны гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

Ангилал	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Зээл	90 хоног хүртэл	91-150	151-240	241-360	361-ээс дээш

2. Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 145/124 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 1.3 дахь заалтын үйлчлэлийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд түр зогсоосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН